

Дадлагажигчийн мөрдөх журам

(Зорилго)

1-р зүйл Энэхүү журамд Ердийн санхүүгийн эрхтэй хуулийн этгээд Хилийн чанад дах аж үйлдвэрийн хүний нөөцийн хөгжлийн Нийгэмлэг(цаашид “Нийгэмлэг” гэх)-ийн хэрэгжүүлэх дадлагажигч хүлээн авах үйл ажиллагааны хүрээнд, гадаад орноос ирсэн дадлагажигчийг дадлагын хугацаанд мөрдүүлэх ёстой зүйлүүдийн талаар заасан болно.

(Хууль тогтоомж зэргийг сахин мөрдүүлэх)

2-р зүйл Дадлагажигч нь Япон улсын хууль тогтоомж, түүнчлэн хүлээн авагч байгууллагын тогтоосон бүхий л дүрэм журмыг шударгаар сахин мөрдөх ёстой.

2 Өмнөх хэсэгт үндэслэн дадлагажигч нь өөр ажил болон цагийн ажил зэргийг хийж болохгүй.

(Японд ирэхээс өмнө холбоо барих)

3-р зүйл Гадаадын компаниудын хүсэлтээр ирсэн суралцагчид сургалт эхлэх өдрөөс 2 долоо хоногийн өмнө урилгын нөхцөл зөвшөөрсөн бичиг, онгоцны тийз, онгоцны тийзний баримтын хуулбарыг AOTS-д өгч, Япон улсын хууль тогтоомж болон бусад дүрэм журмыг дагаж мөрдөх тухай гарын үсэг, Японд ирэх болон нутаг буцах өдруүдийн талаар AOTS-д холбоо барьж мэдэгдэхгүй бол болохгүй.

(Японд ирэх)

4-р зүйл Суралцагчид нь Японд сургалт эхлэх өдрийн өмнөх өдөр ирсэн байх ёстой. Гэхдээ, зайлшгүй шалтгааны улмаас AOTS нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд сургалт эхлэх өдрийн өмнөхийн өмнөх өдөр Японд ирж болно.

(Дадлагын төлөвлөгөө ба оролцоо)

5-р зүйл Дадлагажигч нь нийгэмлэгийн үйлдсэн дадлагын төлөвлөгөө, эсвэл хүлээн авагч байгууллага нь үйлдэж нийгэмлэгээр батлуулсан дадлагын төлөвлөгөөний дагуу хичээн дадлагажих ёстой.

2 Дадлагажигч нь биеийн байдал тавгүй байх зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаас бусдаар дадлагадаа бүрэн хамрагдах ёстой.

(Ажлын нөхцөл)

6-р зүйл Дадлагажигч нь нийгэмлэгийн тогтоосон стандартын дагуу ажлын нөхцлөөр хангагдана.

(Дадлагажигчийн хүсэл эрмэлзэл ба сэтгэл ханамжгүй байдал)

7-р зүйл Дадлагажигч нь дадлага болон ажлын нөхцөл зэргийнхээ тухайд сайжруулах хүсэлтэй, эсвэл гомдолтой байвал түүнийгээ хэлж болно. Нийгэмлэг саналыг хүлээн авч, холбогдох хүмүүстэй шуурхай ярилцаж зөвшилцсөний үндсэн дээр шаардлагатай бөгөөд боломжтой арга хэмжээг авна. Гэхдээ дадлагажигч нь нийгэмлэгийн эцсийн шийдвэрийг дагах ёстой.

(Аюулгүй байдал зэргийн анхааруулга)

8-р зүйл Дадлагажигч нь дадлагын үйл ажиллагаа үргэлжлэхэд саад учруулахгүйн тулд өөрийн эрүүл мэнд болон аюулгүй байдалдаа сайтар анхаарч ажиллаж амьдрах ёстой.

2 Өмнөх хэсэгтэй уялдуулан дадлагажигч нь автомашин (мотоциклик) хамруулан жолоодж, дугуй унаж болохгүй. Гэхдээ унадаг дугуйны хувьд бол практик сургалтын үед, дадлагажих газар болон дотуур байрны хооронд нийтийн тээврийн хэрэгсэл явдаггүй, өөр арга замаар ажилдаа ирж буцахад бэрхшээлтэй гэж үзвэл, хүлээн авагч байгууллагын аюулгүй байдлын сургалт болон даатгалд хамрагдсанаар ашиглах боломжтой.

(Дотуур байр)

9-р зүйл Дадлагажигч нь нийгэмлэг болон хүлээн авагч байгууллагын заасан, мөн зөвшөөрсөн байранд амьдрах ёстай.

2 Дадлагажигч нь дээр заасан байрнаас бусад газарт хоноглохыг хүсвэл урьдчилан нийгэмлэгээс зөвшөөрөл авах ёстай. Практик сургалтын үед хүлээн авагч байгууллагаараа дамжуулан нийгэмлэгт хүсэлтээ гаргах ёстай.

(Сургалтын төвийн хөл хорио)

10-р зүйл Сургалтын төвийн хөл хорио 23:00 цаг бөгөөд сургалтын төвд байрлаж буй суралцагчид гадагш гарсан бол хөл хорионы цагаас өмнө сургалтын төвд ирэхгүй бол болохгүй. Зайлшгүй шалтгаанаар хөл хорионос өмнө ирж чадахгүй тохиолдолд урьдчилан сургалтын төвд мэдэгдэхгүй бол болохгүй.

(Гэр бүлээ хамт байлгах)

11-р зүйл Дадлагажигч нь гэр бүлээ цуг авчрах болон урих боломжгүй. Харин хүндэтгэн үзэх шалтгааны улмаас зайлшгүй урих шаардлагатай болбол нийгэмлэгээс урьдчилан зөвшөөрөл авах ёстай. Түүнчлэн практик сургалтын үед хүлээн авагч байгууллагаараа дамжуулан нийгэмлэгт хүсэлтээ гаргах ёстай.

(Түр хугацаагаар Япон улсаас гарч явах)

12-р зүйл Дадлагажигч нь Япон улсаас гарч явж болохгүй. Гэвч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас Японоос гарах бол урьдчилж нийгэмлэгийн зөвшөөрлийг авах ёстай. Түүнчлэн практик сургалтын үед хүлээн авагч байгууллагаараа дамжуулан нийгэмлэгт хүсэлтээ гаргах ёстай.

(Даатгал)

13-р зүйл Нийгэмлэг нь, гэнэтийн осол (дадлагатай хамааралтай эсэхийг үл харгалzan)-ын улмаас дадлагажигч гэмтэж бэртэх зэрэг осолд өртөж болзошгүй байдлыг харгалzan дадлагажигчийг даатгуулагч болгон даатгалын компанийг гэрээ хийлгүүлнэ. Гэрээ нь гадаадад аялагчдын даатгалын гэрээнд үндэслэх ба үүгээр эмнэлгийн тусламж үйлчилгээ авч болно. Даатгалын төлбөрийг нийгэмлэг хариуцана.

2 Дадлагажигч нь тэрхүү даатгалын гэрээнд заагдсан эмчилгээний төлбөрийн дээд хязгаарыг давсан өндөр өртөгтэй эмчилгээ хийлгэх шаардлагатай болбол нийгэмлэгт урьдчилж мэдэгдэн, нийгэмлэгээс шийдвэр гаргаж өгөхийг хүснэ. Харин практик сургалтын үед хүлээн авагч байгууллагаараа дамжуулан нийгэмлэгт хүсэлтээ гаргах ёстай.

3 Дадлагажигч нь өвчин эмгэг, бэртэл гэмтлээс үүдэн эмнэлэгт хэвтэх, дадлагад саад учруулах бусад нөхцөл шалтгаан үүссэн бол хүлээн авагч байгууллага болон нийгэмлэгт мэдэгдэх ёстай.

4 Нийгэмлэг нь, 1-р заалтын осол зээргээс үүдэлтэй дадлагажигчид учирсан хохирлын тухайд даатгалын компаниас хариуцах мөнгөнөөс бусдаар хохирол барагдуулах үүрэг хүлээхгүй.

(Дадлагажигчийн хариуцлагаас үүдэлтэй хохирол)

14-р зүйл Дадлагажигчийн осол, гэнэтийн үйлдлээс болж, нийгэмлэг ба хүлээн авагч байгууллагад хохирол учирсан бол дадлагажигчид нийгэмлэг ба хүлээн авагч байгууллагаас хохирлын нөхөн төлбөр нэхэмжилж болно.

(Дадлагажигч байх эрхээ алдах)

15-р зүйл Дадлагажигч нь дараах зүйлүүдийн аль нэгэнд хамаарах үйлдэл гаргасан бол дадлагажигч байх эрхээ алдах тохиолдол байж болно.

- (1) Тус журмаар заасан зүйлийг зөрчсөн бол
- (2) Ур чадвар бууран, дадлага хийх эрмэлзэлгүй болсон, эсвэл зан ааш дадлагад хандах байдал доройтсон, дадлагыг үргэлжлүүлсэн ч хүсэн хүлээсэн үр дүнд хүрэхгүй нь тодорхой болсон бол
- (3) Өвчин эмгэг, бэртэл гэмтлээс үүдэн дадлагaa үргэлжлүүлэх боломжгүй болсон гэж үзвэл
- (4) Нийгэмлэгийн нэр төр, итгэлийг илтэд сэвтээсэн үйлдэл үйлдсэн бол

- (5) Дээрх 1-4-р заалтыг үндэслэх шалтгаан байгаа бол
- 2 Дадлагажигч нь, нийгэмлэг болон хүлээн авагч байгууллагын хоорондын дадлагажигч хүлээн авах гэрээ цуцлагдах, эсвэл дадлагыг зогсоох үед дадлагажигч байх эрхээ автоматаар алдана.
- 3 Дадлагажигч нь 1 ба 2-р заалтад заасан шалтгааны улмаас дадлагажигч байх эрхээ алдвал, зарчмын хувьд тухайн өдрийг хүртэл дадлагажигчийн дадлага болон оршин суух үйл ажиллагаанд зарцуулсан бүх зардлыг, эсвэл зарим хэсгийг хүлээн авагч байгууллагаар дамжуулан, эсвэл шууд нийгэмлэгт буцааж төлөх ёстай.

(Нутаг буцах)

- 16-р зүйл** Дадлагажигч нь дадлагаа дуусгасан үедээ, эсвэл дадлагажигч байх эрхээ алдсан тохиолдолд түргэн нутаг буцах ёстай. Харин нийгэмлэгийн зөвшөөрөл авсан бол энэ заалтад хамаарахгүй.
- 2 Өмнөх заалтад оруулсан тохиолдоос бусдаар, дадлагажигч нь дадлага дууссаны дараа 8-аас дээш өдөр оршин суух тохиолдолд нийгэмлэгийн зүгээс буцах замын зардлыг төлөхгүй.
- 3 12-р зүйлийн 3-р заалтын журмыг өмнөх заалтын тохиолдолд тохируулан хэрэглэнэ.

(Төгсөлтийн сертификат)

- 17-р зүйл** Дадлагажигч нь дадлагаа амжилттай дүүргэсэн үед “Дадлагын төгсөлтийн сертификат олгох журам”-д үндэслэн нийгэмлэгээс төгсөлтийн сертификат гардуулна.

(Бусад заалт)

- 18-р зүйл** Энэ журмаар тогтоогоогүй зүйл, мөн илүү нарийн төвөгтэй зүйлийн тухайд бол, нийгэмлэг тухай бүрт нь журамлан тогтооно.

Нэмэлт заалтууд

Энэ журам нь он /2019 он/-ы 4-р сарын 1-ээс Хэрэгжинэ.